


БАТЛАВ:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Я.АМАРЖАРГАЛ

ШИНЭ КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
/БАГЦ-1: ХҮЧИЛТӨРӨГЧИЙН КОМПРЕССОР/ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 292

НИЙЛҮҮЛЭГЧ:

"СИ ДАБЛЮО ЭМ ЖИ ЭЛ" ХХК-
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.ДАСТАН

Улаанбаатар хот

Нэг талаас "Эрүүл мэндийн яам" (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "Би Даблью Эм Жи Эл" ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 7 дугаар сарын 30-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Шинэ коронавируст халдвартын үед эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж /Багц-1: Хүчилтөрөгчийн компрессор/-ийг нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч гэрээ байгуулав. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 45,998,800₮ /Дөчин таван сая есөн зүүн ерэн найман мянга найман зуу/ төгрөгөөр Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлнэ. 2020 онд санхүүжих дүн 45,998,800₮ /Дөчин таван сая есөн зуун ерэн найман мянга найман зуу/ төгрөгийг тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгснөөс хойш 30 хоногийн дотор нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь доорх нэр төрлийн барааг, талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 120 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

№	Материал дугаар	Барааны нэр	Тоо/ш	Нэгж	Нэгжийн үнэ	Дүн
1	ASK 34	KAESER хүчилтөрөгчийн компрессор загвар: AK34/8.5 Bar	1	Ш	38,374,700₮	38,374,700₮
2		Сэнсэн хөргүүрийн цахилгаан мотор /3фаз, 0,55 кВт/	1	Ш	5,743,300₮	5,743,300₮
3		Жийргэвч	1	Ш	1,870,800₮	1,870,800₮
НИЙТ ДҮН (НӨАТ-ГҮЙ)						45,988,800₮

5. Захиалагч болон нийлүүлэгч байгууллагын зүгээс үл хамаарсан хучин зүйлсийн улмаас гэрээний зарим зүйл заалт биелүүлэх хугацаа хойшлогдсон тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож, зөвшилцөн шийдвэрлэнэ.

6. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Бусад шаардлагатай баримт бичиг;
 Тендерийн баталгаа;
 Тендер ба үнийн хуваарь;
 Гэрээний тусгай нөхцөл;
 Гэрээний ерөнхий нөхцөл;
 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
 Санхүүжилтийн хуваарь;
 Баталгаат хугацааны мэдэгдэл /албан тоот/
 Гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл /албан тоот/

7. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

8. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

9. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан ўргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Нарантуяа

Хуулийн хэлтсийн дарга

М.Ганзориг

Хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан ўргийг түр орлон гүйцэтгэгч

Т.Бямбасүрэн

Хуулийн хэлтсийн гэрээний мэргэжилтэн

Д.Мөнхцэцэг

Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Г.Бат-Эрдэнэ -2

Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн газрын VIII байр, 1 давхар 106 тоот брөө Улаанбаатар-48, Олимпийн тутамж-2
Утас: 51-263631, Факс: 323541

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Борлуулалтын менежер

Ч.Цэрэндорж

Хууль, Ёс зүй, ХАБЭА хариуцсан менежер

Н.Мөнхтүлга

Хаяг: "Си Даблью Эм Жи Эл" ХХК, One residence хотхон, 26д байр, 1 тоот, Юнескогийн гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Утас: 77208088

И-мэйл: sales@cwmongolia.com

Дансны дугаар: 5175014053

ХААН банк